



From  
the People of Japan



НҮБ-ын Хүн Амын Сан



НҮБ-ын Хүүхдийн Сан

# COVID-19

ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ ФРОНТ ДЭЭР  
АЖИЛЛАЖ БУЙ АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДАД  
ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ,  
ХҮҮХДИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ИЛРҮҮЛЖ, ХАРИУ  
АРГА ХЭМЖЭЭ АВАХАД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ



## ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ ФРОНТ ДЭЭР АЖИЛЛАЖ БҮЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ<sup>1</sup>

### Баримтлах зарчим:

Жендэрт суурилсан хүчирхийлэл түүний дотор гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг илрүүлэх үзлэгийг бүх хүнд хийхийг тэр бүр зөвлөдөггүй, учир нь хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг тодорхойлж, эмчлэх нь таны хүлээсэн үүрэг биш байдаг. Харин хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй шинж тэмдэг байгаа эсэхийг шалгаж, үйлчлүүлэгчийн санал хүсэлт, сонголтыг хүндэтгэн үзэж, мэргэжлийн шаардлагатай тусламж үйлчилгээг хэрхэн яаж авах тухай үнэн зөв мэдээлэл өгөх нь таны үүрэг юм.

Жендэрт суурилсан хүчирхийлэл/гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй эсвэл хүчирхийлэлд өртсөн хүмүүстэй харьцахдаа:

- Шууд цочмог асуулт асуухгүй байх
- Болсон явдлаа ярьж байхад нь яриаг нь таслахгүй байх
- Хүчирхийлэлд өртсөн шинж тэмдэг тухайн эмэгтэйд байгаа эсэхийг хайх
- Хувийн нууцыг хадгалах
- Анхааралтай сонсох
- Тэвчээртэй, тайван байх

### Гэр бүлийн хүчирхийллийн ямар шинж тэмдэг байдаг вэ?

Таныг үүрэгт ажлаа гүйцэтгэж байх үед хэн нэгэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөнөө танд мэдэгдэж магадгүй. Гэвч ихэнх тохиолдолд хүчирхийлэлд өртсөн хүмүүс ялгаварлан гадуурхалтад өртөж, хангалттай мэдээлэл авч чаддаггүй тул хүчирхийлэлд өртөгсдийн ихэнх нь нөхцөл байдлаа тэр бүр бусдад мэдэгддэггүй. Гэр бүлийн хүчирхийлэлийн тохиолдол бүр өөр өөр. Иймд илрэх шинж тэмдэг нь ч бас тохиолдолоос шалтгаалан янз бүр байдаг ч дараах нийтлэг шинж тэмдэг илэрч байгаа эсэхийг ажиглаарай. Үүнд:

- Бие махбодын гэмтлээ өөрсдөө тайлбарлаж чадахгүй байх, эсвэл ямар нэг шалтаг хэлэх
- Чимээгүй, айдастай эсвэл маш их санаа зовсон байдалтай байх
- Өвдөлтөө тайлбарлаж чадахгүй байх
- Хамтрагчаасаа айж эмээх, хамтрагчийнхаа санаанд нийцүүлэх гэж хэт их санаа зовох
- Жижиг асуудлыг ч хамтрагчаасаа байнга асууж, лавлан, зөвшөөрөл хүсэх,
- Хүүхдүүд ямар нэг том хүн эсвэл насанд хүрсэн хүмүүсээс айж эмээсэн байдлаар харьцаж байх.

### Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг тодорхойлох шууд бус асуултууд:

- Гэрт чинь таны санааг зовоосон асуудал бий юу? Олон эмэгтэй гэртээ янз бүрийн асуудалд санаа зовдог. Тиймээс асуудалтай тулгарч байгаа хүн та ганцаараа биш.

1 НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сангийн техник арга зүйн дэмжлэгтэйгээр Фижи улсын Эмэгтэйчүүд, хүүхдийг дэмжиж, ядуурлыг устгах яамны боловсруулсан “Жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийллийг илрүүлэхэд зрүүл мэндийн ажилтнуудад зориулсан зөвлөгөө”, “Эмэгтэйчүүд, хүүхдүүдийг хүчирхийлэлд өртсөн эсэхийг тодорхойлж, зохих үйлчилгээнд зуучлахад зрүүл мэндийн ажилтнуудад зориулсан удирдамж”-аас Монголын нөхцөлд нийцүүлэн энэ зөвлөгөөг бэлтгэв.

- Хөл хорионы үеэр та гэр бүлтэйгээ хамт баймаар байна үү? Эсвэл өөр газар, тусдаа байрламаар байна үү?
- Тусламж, үйлчилгээ авах боломжтой юу? Өөртөө шаардлагатай тусламж, үйлчилгээнд мөнгө захиран зарцуулах эрхтэй юу?
- Аюулгүй, амгалан тайван байрлах газар бий юу? Эсвэл байрлахад танд болон хүүхдүүдэд чинь аюултай байж болох газар бий юу?

Хариултуудаас нь шалтгаалан үргэлжлүүлэн асуулт асуух эсэхээ шийднэ. Гэхдээ мэдрэмжтэй байж, хүчирхийллийн талаар шууд асуухаас зайлсхийгээрэй. Дээрх асуултуудын аль нэгд нь “тийм” гэж хариулсан тохиолдолд тухайн хүний хэрэгцээг үнэлж, дэмжлэг тусламж санал болгох нь зүйтэй. Эсвэл энэ чиглэлээр ажилладаг байгууллагад хандахыг зөвлөөрэй. Нэг цэгийн үйлчилгээний төв/түр хамгаалах байрнуудтай холбогдох утасны жагсаалтыг хамгийн арын хуудаснаас үзнэ үү.

### **Хэн нэгнийг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэж сэжиглэсэн тохиолдолд та уухийх хэрэгтэй вэ?**

Хэн нэгнийг ГБХ-ийн хохирогч байж болзошгүй хэмээн сэжиглэж байгаагаа холбогдох хүмүүст мэдэгдсэнээр тэдний амийг аврах боломжтой. Хүчирхийлэлд өртөгсөдтэй харьцахдаа дараах зүйлд анхаарна. Үүнд:

- Шүүмжлэхгүй байх, ойлгож, дэмжиж харьцах. Тэдэнд эелдэг сайн хандаж, тэднийг буруутгахгүй байх.
- Тэвчээртэй байх. Анхааралтай сонсож, яриаг тасалдуулахгүй байх. Тэдэнд итгэж, ярьсан зүйлийг нь бататгах.
- Хүчирхийллийн тухай асуухдаа эхлээд ерөнхий, танилцах зорилго бүхий асуултуудыг асууж, тэдний итгэлийг олж, чөлөөтэй тайван ярих ая тухтай уур амьсгалыг бүрдүүлсэний дараа тусгай асуултуудыг асууна.
- Нөхцөл байдлаа тайлбарлахыг шахааж, шаардаж болохгүй. Тэд ярих хүсэлгүй байвал дараа ярих санал тавьж болно.
- Хүчирхийллийн хохирогч үйлчилгээ авах хүсэлт гаргавал тусламж үйлчилгээнүүдийн талаар танилцуулж, доорх дугаарууд руу утасдаж, зөвлөгөө авах юмуу эсвэл хамгийн ойр байрлах нэг цэгийн үйлчилгээний төв/түр хамгаалах байртай холбогдож, тусламж үйлчилгээ авах боломжтойг тайлбарлах, шаардлагатай бол тэдэнтэй холбож өгөх.
- Ямар тусламж үзүүлэх боломжтойг хэлж, тусламжийн хувилбаруудыг тэдэнтэй ярилцах. Өөртөө хамгийн тохиромжтой тусламжийг сонгохыг санал болго. Ингэхдээ тэднийг шахааж хүчилж болохгүй. Хүссэнээ ярих эсэхээ шийдэх хугацаа тэдэнд олго.

Жендэрт суурилсан хүчирхийллээс ангижирч, хэвийн амьдралдаа эргэн ороход нь туслах, тэдэнд мэдрэмжтэй, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх газруудтай холбон өгөх хэрэгтэй. Дараах дугааруудаас аль нэг рүү нь холбогдож, шаардлагатай үйлчилгээгээ авах боломжийг тэдэнд олгох:

**102 – Цагдаагийн дүүдлага**

**107 – Нийслэлийн цагдаагийн түр хамгаалах байр**

**108 - Хүүхэд хамгааллын утас**

*Тусламж үйлчилгээ авах эсэхээ хохирогч өөрөө шийднэ. Тэдний амь насанд аюул учирч болзошгүй байгаа тохиолдолд цагдаад мэдэгдэх ёстой.*

## **Хүчирхийллийн хохирогч нь хүүхэд байвал яах вэ?**

Хүүхэд хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй тохиолдолд ямагт Хүүхэд хамгааллын 108 дугаар руу утасдаж мэдэгдэх үүрэгтэй. Хүүхэд аюултай нөхцөлд байна гэж сэжиглэсэн тохиолдолд тухайн хүүхдийг байлцуулан Хүүхэд хамгааллын 108 дугаар руу утасдаж, холбогдоорой. Нийгмийн ажилтан юмуу эсвэл цагдаа ирж, уг хүүхдийг хамгаалалтад автал түүнтэй хамт байх нь зүйтэй.

## **Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?**

Хүчирхийллийн хохирогчдыг хамгийн ойр байрлах Нэг цэгийн үйлчилгээний төв юм уу эсвэл түр хамгаалах байр руу зүүчилж болно. Тэнд аюулгүй байраар хангахаас гадна хамгаалал, хууль эрх зүй, нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй авах боломжтой. Нэг цэгийн үйлчилгээний төв/түр хамгаалах байрнуудтай холбогдох утасны жагсаалтыг хамгийн арын хуудаснаас үзнэ үү.

## **ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТУХАЙ**

### **Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж юу вэ?**

Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж тухайн хүний хүйс, жендэрийн онцлог, түүнтэй холбоотой нийгмийн тэгш бус харьцаанаас үүдэн гардаг хүчирхийлэл юм. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь хүний эрхийн ноцтой зөрчил бөгөөд охид, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцаанд орох эрхийг хязгаарлаж, эрүүл мэнд, нийгмийн байдалд нь ноцтой үр дагаврыг учруулдаг.

Гэр бүлийн хүчирхийлэл бол тухайн эмэгтэйн нөхөр, найз залуу зэрэг хамгийн ойр дотны хамтран амьдрагчын зүгээс өөрийн эрхшээлд байгаа ойр дотны хүний эсрэг үйлддэг жендэрт суурилсан хүчирхийллийн хамгийн түгээмэл хэлбэр юм. Эмэгтэйчүүдээс гадна хүүхэд, ахмад настан, ЛГБТ хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх хамгийн их эрсдэлтэй.

### **Жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд**

- Бие махбодын хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Сэтгэл санааны хүчирхийлэл (тухайлбал, гутаах, заналхийлэх, доромжлох, дарамтлах, хардах)
- Эдийн засгийн хүчирхийлэл (тухайлбал, өрхийн хөрөнгө нөөцөд хяналтаа тогтоон, хамтран амьдрагчдаа хөрөнгө нөөц өгөхгүй сүрдүүлэх, заналхийлэх)

### **Жендэрт суурилсан хүчирхийлэл яагаад гардаг вэ?**

Жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондох эрх мэдлийн ялгаатай, тэгш бус байдал, бүгшсан ялгаварлан гадуурхалт бүхий соёл уламжлал, итгэл үнэмшил юм. Боловсролын түвшин бага, амьдралын боломж хомс байх, ядуурал, архидалт, хямрал, цар тахлын онцгой байдал бол хүчирхийллийг өдөөгч хүчин зүйлс юм.

### **Жендэрт суурилсан хүчирхийллийн үр дагавар юу вэ?**

Жендэрт суурилсан хүчирхийллийн улмаас хүмүүс бие махбод, сэтгэцийн эрүүл мэндээр хохироод зогсохгүй эд хөрөнгөөрөө хохирч, амь насаа алдах тохиолдол ч гардаг. Бага залуугаасаа жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хохирогчид ялангуяа хүүхдүүд амиа

хорлох, архинд донтох болон өөр бусад хорт зуршилд автах эрсдэл ихтэй байдаг. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь нийгэм, эдийн засагт сөрөгөөр нөлөөлөөд зогсохгүй улс оронд бүхэлд нь нөлөөлдөг. Жендэрт суурилсан хүчирхийллийн улмаас хөдөлмөрийн бүтээмж алдагдаж, дундажаар тухайн орны ДНБ-ий 1.2-3.7%-тай тэнцэхүйц алдагдал гардаг байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэгчдийг зохих ёсоор шийтгээгүйн улмаас тухайн улсад хүчирхийлэл үйлдэгчид шийтгэл хүлээдэггүй практик бий болгодог.

### **Жендэрт суурилсан хүчирхийлэл Монголд гардаг уу?**

Гардаг! 2017 онд Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хүн амын сан хамтран үндэсний түвшинд хийсэн хүчирхийллийн тархалтын талаарх судалгаанаас үзэхэд Монголд 2 эмэгтэй тутмын 1 нь ойр дотно хамтран амьдрагчийнхаа үйлдсэн ямар нэг хэлбэрийн хүчирхийлэлд амьдралынхаа аль нэг үед өртсөн байдаг бол 3 эмэгтэй тутмын 1 нь бие махбодын болон /эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Өнгөрсөн 12 сарын хугацаанд 3 эмэгтэй тутмын 1 нь ойр дотно хамтран амьдрагчийнхаа үйлдсэн ямар нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд энэхүү хүчирхийллийн 10 тохиолдол бүрийн 1 нь бэлгийн болон/ эсвэл бие махбодын хүчирхийлэл байна.

Хохирогчдыг хамгаалж, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэхийн тулд Монгол Улсын Их Хурал Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн баталж, гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцож, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага тооцож, шийтгэл хүлээлгэдэг болсон. Үүний үр дүнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, үр дүнтэй хариу арга хэмжээ авахад чухал ач холбогдолтой бөгөөд үүний үр дүнд хүчирхийлэл үйлдэгчдэд хуулиар хариуцлага хүлээлгэхийн сацуу хохирогчдыг хамгаалах эрх зүйн орчин бүрдлээ. Энэ хуулиар мөн хүчирхийлэл үйлдэгчдийг албадан сургалтад хамруулж, хандлага, үзэл бодлоо өөрчилж, цаашид хүчирхийлэл үйлдэхгүй болгоход анхаарч байна.

### **COVID-19 цар тахал жендэрт суурилсан хүчирхийлэлд хэрхэн нөлөөлж байна вэ?**

Аливаа онцгой байдлын үед жендэрт суурилсан хүчирхийлэл нэмэгдэх хандлагатай байдаг нь олон улсын туршлагаас тодорхой болсон. COVID-19 цар тахал дэлхийд тархсанаас хойш жендэрт суурилсан хүчирхийлэл ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн бүртгэгдсэн тохиолдлын тоо дэлхий дахинаа эрс өсч, энэ үзэгдэл Монголд ч бас ажиглагдаж байна. COVID-19 цар тахлын онцгой байдлын үед жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл газар авах эрсдэл өндөр байна. Цар тахлын тархалтыг бууруулах зорилгоор авч буй хөл хорио, сургууль, соёлын байгууллагууд хаагдсан, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хориглосон зэрэг нь хүн амын дунд стрессийн түвшинг нэмэгдүүлснээр жендэрт суурилсан хүчирхийлэл нэмэгдэх эрсдлийг ихэсгэж байна. Мөн хүмүүс бүхимдаж, стресстэх нь ихсэж, эдийн засгийн эх үүсвэрүүд хумигдаж, хөл хорионы улмаас хүчирхийлэл үйлдэгчтэй гэртээ байнга хамт байж, тусламж үйлчилгээнээс тусгаарлагдаж, нэн шаардлагатай үйлчилгээний хүртээмж багассаны улмаас жендэрийн тэгш бус байдал, хорт дадал зуршил улам гаарч, жендэрт суурилсан хүчирхийллийг ихэсхэд хүргэж байна. 2020 оны эхний улиралд COVID-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж эхлэх үед гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол 2019 оны 1-р улиралтай харьцуулахад 46.92%-иар (гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 27.2%-иар буурсан ч зөрчил 61.6%-иар нэмэгдсэн) өсчээ. Мөн гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмтэж бэртсэн хүний тоо 55.6%, эд хөрөнгийн хохирол 23.4%-иар өссөн байна. Мөн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийг үйлчилгээний төв болон түр хамгаалах байруудаар үйлчлүүлсэн

иргэдийн тоо 2020 оны эхний улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 89%-иар өссөн байна.

Цар тахлын үед хүүхдүүд бие махбодын хүчирхийлэлд өртөх, эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдүүдийг үл хайхрах явдал ихсэж байна. Хөл хорио тогтоож, сургуулиудыг хаасны улмаас хүүхдүүд, өсвөр үеийнхэн уйдаж, ганцаардан, уурласнаасаа болж эцэг эхтэйгээ сөргөлдөж, энэ сөргөлдөөн нь даамжирсаар сэтгэл санаа, бие махбодын хүчирхийлэл болон хувирч байна. Бүртгэгдсэн тохиолдлуудын тоон мэдээллээс үзвэл 2020 оны 3-р сард бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 2019 оны 2-р сарынхтай харьцуулахад 46.8%-иар, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн тоо 57.6%-иар өссөн байна.

### **ЖСХ/ГБХ-ИЙН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХАД ТУСЛАМЖ ШААРДЛАГАТАЙ БОЛ ДАРААХ УТСААР ХОЛБОГДОНО УУ**

<b>Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ)</b>		
<b>#</b>	<b>Байршил</b>	<b>Утас</b>
1	Баянхонгор аймаг	70442122
2	Баян-Өлгий аймаг	7042102, 94442902
3	Говь-Алтай аймаг	7048103, 7048102, 98299111
4	Завхан аймаг	7046102, 80740740
5	Дархан-Уул аймаг	88184751
6	Дорнод аймаг	70584455, 70584150, 99765250
7	Өвөрхангай аймаг	70322108
8	Өмнөговь аймаг	70532005
9	Хөвсгөл аймаг	70382121
10	Хэнтий аймаг	70563433, 92070103
11	Улаанбаатар хот: Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дэргэдэх НЦҮТ	70180139
12	Улаанбаатар хот: Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн дэргэдэх НЦҮТ	70116358
13	Улаанбаатар хот: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дэргэдэх НЦҮТ	93070949
14	Улаанбаатар хот: Хан-Уул дүүрэг дэх НЦҮТ	88127821, 88049073, 89893773
15	Улаанбаатар хот: Баянзүрх дүүрэг дэх НЦҮТ	70150183

### Түр хамгаалах байр (ТХБ)

#	Байршил	Утас
1	Архангай аймаг	94668379
2	Булган аймаг	70343389 94115543
3	Говьсүмбэр аймаг	99941951
4	Дорноговь аймаг: Сайншанд	70522738 88032134 99064542 99411406
5	Дорноговь аймаг: Замын-Үүд	89112271 91213313
6	Дундговь аймаг	96010665 80116322 90905616
7	Сэлэнгэ аймаг: Мандал	99536561
8	Сэлэнгэ аймаг: Алтанбулаг	99684695
9	Увс аймаг	99042434 99679379
10	Улаанбаатар хот: Багахангай дүүрэг	70491049 70491216 88661861
11	Улаанбаатар хот: Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ	89040108 88028782
12	Улаанбаатар хот: Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	70119949 96490505
13	Улаанбаатар хот: Нийслэлийн цагдаагийн газрын дэргэдэх ТХБ	107

